

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЧУЛУУНБААТАРЫН ЭНХ-ОТГОНЫ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		
Зорилт 1.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.								
1.	Арга хэмжээ 1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, газрын даргын хурлаар хэлэлцүүлэн, зөвлөмж хүргүүлэх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	10	5	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан зэрэг 10 баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 90,0 хувь, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 93,3 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 2 зорилтын 17 арга хэмжээний хэрэгжилт 58,6 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт (түүвэр) 89,3 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 81,1 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 98.3	01-06	70	

					хувь, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайлан 78.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.		
2.	Арга хэмжээ 1.2 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын байгууллагын чиг үүрэгт хамаарах заалтын тайланд хяналт шинжилгээ, үнэлгээг тогтоосон хугацаанд хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90-100	90-100	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт (түүвэр) 89,3 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 81,1 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 98,3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан.	01-06	
	Арга хэмжээ 1.3 Төсвийн Ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах 2025 оны "Хариуцлагын гэрээ"-ний тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	1	1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас нийслэлийн аялал жуулчлалын газрын даргатай 2025 онд байгуулсан "Хариуцлагын гэрээ"-ний 24 заалтын хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийхэд "Хариуцлагын гэрээ"-ний хэрэгжилт 2025 оны хагас жилийн эхний байдлаар 89,5 хувьтай буюу "Үр дүнтэй" хэмээн үнэлсэн.	01-06	
3.	Арга хэмжээ 1.4 Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээг тогтоосон хугацаанд хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90-100	90-100	Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж 2025 оны эхний хагас жилийн байдлаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт 90,0 хувь, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 93,3 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 2 зорилтын 17 арга	01-06	

					хэмжээний хэрэгжилт 58,6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан.		
5.	Арга хэмжээ 1.5 Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөмж хүргүүлэх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	2	1	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын нийт 53 арга хэмжээ тусгагдсан. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг баримтлан байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр хяналт-шинжилгээ хийлээ. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилтын 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 78.4%-тай "Хангалттай" гэж үнэлэгдсэн. Үнэлгээг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох албан хаагчдад зөвлөмж өгч ажилласан.	01-06	70
7.	Арга хэмжээ 1.6 Газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	2	1	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн 15 үндсэн үүргийн хэрэгжилт "74.0 хувь буюу хангалттай" хэмээн хяналт шинжилгээ, үнэлгээгээр үнэлэгдсэн.	01-06	100
9.	Арга хэмжээ 1.7 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тогтоосон хугацаанд тайлагнана.	Цахимаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	-	12	Нийслэлийн удирдах ажилтнуудын 11 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 31 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын	01-06	100

					газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн тайлагнан ажилласан.		
7.	Арга хэмжээ 1.8 Байгууллагын дотоод ажлын чиг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	90%	2025 онд цаг үеийн шинжтэй дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллалаа. 1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/33 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын даргын баталсан "Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх ажлын удирдамж"-ийн хүрээнд батлагдсан хуваарийн дагуу нийслэлийн Аялал жуулчлалын газрын 9 албан хаагч Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт хийх, зөвлөгөө зөвлөмж хүргэх ажлыг хамтранг зохион байгуулж ажилласан. 2.Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хороотой хамтран "Хайраа хайрлая, Хандлагаа өөрчилъе, Хамтдаа үлгэрлэе" уриан дор зохион байгуулагдсан "Харилцан хүндэтгэе" аянд нийслэлийн Аялал жуулчлалын газрын хамт олон нэгдэж 2 төрлийн баннер, бичлэгийг байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан 6,000 гаруй хүнд хүргэсэн. Мөн жендерийн эрх тэгш байдлыг хангах, албан хаагчдын мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилгоор "Жендерийн	02-06	

					мэдрэмжтэй төлөвлөлт” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. 3. Нийслэлийн удирдах ажилтнуудын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүргийн дагуу Улаанбаатар хотын менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын баталсан хуваарийн дагуу нийслэлийн Аялал жуулчлалын газрын 8 албан хаагч Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт эзэнгүй нохой, муурыг барих, тоог бууруулах ажлыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллагуудтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 24,25-ны өдрүүдэд зохион байгуулсан.		
Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
1.	Арга хэмжээ 2.1 Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, заавар, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн хувь	90%	95%	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу зохион хөтөлж, албан тушаалын чиг үүрэгтэй холбоотой ирсэн нийт 7 албан бичгийг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн. Хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй.	01-06	100
2.	Арга хэмжээ 2.2 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны хадгаламжийн нэгж үүсгэж, тогтоосон хугацаанд хүлээлгэн өгнө.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 2 хадгаламжийн нэгж үүсгэж, тогтоосон хугацаанд хүлээлгэн өгсөн.	01-06	80
3.	Арга хэмжээ 2.3 Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар өгсөн үүрэг даалгавар бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	- Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд 2025 оны 01 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гарган, хяналт, шалгалт хийсэн. - Монгол Улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Фестиваль зохион байгуулах тухай” 41 дүгээр тогтоол, Монгол Улсын Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын сайдын 2025 оны 01 дүгээр	01-06	100

					сарын 30-ны өдрийн А/17 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын 02 дугаар сарын 11-ний А/167 дугаар захирамжийн хүрээнд газрын даргын 2025 оны А/07 дугаар тушаалаар биет бус өвийн төрөл зүйлийг дотоод гадаадын жуулчдад сурталчлах, түгээн дэлгэрүүлэх замаар үндэсний брэнд өвлийн эвентийг бий болгох зорилгоор "МОНГОЛ" нүүдэлчин өвлийн фестивалийн "Монгол үндэстэн угсаатан жагсаал"-ыг хөтөлбөрт багтсан хуваарийн дагуу 2025 он 02 дугаар сарын 16-ны өдөр үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулахад хамтарч ажилласан.		
--	--	--	--	--	---	--	--

Зорилт 3. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.	Арга хэмжээ 3.1 Хариуцсан чиглэлийн хүрээнд сургалт, семинарт, зөвлөгөөнд хамрагдаж тухай бүр мэдлэг чадвараа дээшлүүлнэ.	Хамрагдсан сургалтын тоо	6	4	1. Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдаж тэнцэн АЗ сертификат гэрчилгээг авсан. 2. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, харилцаан хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулж байгууллагын албан хаагчдыг хамруулсан.	01-06	70
3.	Арга хэмжээ 3.2 Солонгос хэлний сургалтад хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлнэ.	Цаг	-	144	Солонгос хэлний анхан шатны 50 цагийн сургалтад хамрагдаж хэлний мэдлэгээ дээшлүүлсэн.	01-06	90

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
-----	-------------------------------	------------------	--------------	--------------	-------------------------	--------------------------	-----------------

3.	Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, ёс зүйн дэд хорооны даргаар батлуулсан. Ажлын төлөвлөгөөнд 13 арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх, албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Ёс зүйн дэд хорооноос "Ажилтны ёс зүй, харилцаа хандлага"-ын судалгааг 13 асуулгын хүрээнд боловсруулж, Google forms программ ашиглан байгууллагын 18 албан хаагч хамрагдаж, өөрсдийн тулгамдаж буй хэрэгцээний талаар санал асуулгад хариулт өгсөн байна. Судалгааны үр дүнг нийт албан хаагчдад танилцуулсан. Уг судалгаагаар албан хаагчид харилцаа хандлага, байгууллагын соёл гэсэн чиглэлээр сургалтад хамрагдах хүсэлтэй байсан тул энэ чиглэлийн сургалт, нөлөөллийн чиглэлийн арга хэмжээнүүдийг 2 дугаар улиралд төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажилласан.	01-06	32

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЭНХ-ОТГОН

Ч.ЭНХ-ОТГОН

2025 оны дугаар сарын